

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,  
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ

2016 оны 03 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 195/204

Улаанбаатар хот

Агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, бүсэд мөрдөх журам  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААЖ, ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын "Агаарын чанарыг сайжруулах бүс"-ийг нэгдүгээр, Бүсэд мөрдөх журамыг хоёрдугаар, хилийн зааг байршлыг харуулсан 1:25000-аас доошгүй масштаб бүхий газрын зургийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Даланзадгад сумын "Агаарын чанарыг сайжруулах бүсийн хилийн зааг" тогтоосон талаар олон нийтэд зарлан мэдээлэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Хэвлэл, мэдээллийн алба /Г.Ганхуяг/, Өмнөговь аймгийн олон нийттэй харилцах алба /Р.Оюунсүрэн/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал, захирамжийг хэрэгжүүлж хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Цэнгэл/, Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Б.Дэндэвсамба/, Өмнөговь аймгийн Засаг даргын орлогч /Д.Нацагдорж/-д тус тус даалгасугай.

БАТЛАВ:  
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН  
ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД



Н.БАТЦЭРЭГ

БАТЛАВ:  
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА




Б.БАДРАА

Байгаль өрчин, ногоон хөгжил, аялал  
 жуулчлалын сайд, Өмнөговь аймгийн Засаг даргын  
 Хамтарсан 2016 оны 02 сарын 23-ны өдрийн  
 А75/А204 тушаал, захирамжийн нэгдүгээр хавсралт

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЗАДГАД СУМЫН АГААРЫН ЧАНАРЫГ  
 САЙЖРУУЛАХ БҮСЭД ХАМРАГДАХ БАГУУД

Багууд	Багуудын гудамж, бүсийн ангилал		
	Онцгой бүс	I бүс	II бүс
	Түлшинд хэмнэлттэй сайжруулсан зуух, цахилгаан, хийн халаагуур, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хэрэглэх бүс	түлшинд хэмнэлттэй сайжруулсан зуух, түлш хэрэглэх бүс	Дараагийн шатанд түлшинд хэмнэлттэй зуухаар хангах бүс
Баруун сайханы I баг	Баруун сайхан, Төгөл, гурвансайханы гэр хороолол	-	-
Хан-Уулын II баг	Хан-Уул,ын 1-24-р гудамж, ИУ-ын 14-34 гудамж, Ёл,Нисэх гудамжууд	-	-
Далангийн III баг	-	Багийн төв доторх гэр байрууд	ДДЦС-ийн баруун талын гудамж, УАА-н гэр хороолол
Дундсайханы IV баг	Хийд хороолол	дс—1-8 гудамж, 1а,б,в-ийн 1-7-р гудамж	-
Зүүн сайханы V баг	-	-	ЗС-ны гэр хороолол Ногоочдын гудамж, далангийн гудамж
Их-Уулын VI баг	-	жу-1-9 гудамж, бу-1-8 гудамж	-
Оюутын VII баг	-	от-1-12-р гудамж	-
Цагаан булагийн VIII баг	-	-	Начин, Аргалант, малчны хороолол, радио телевиз



Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Өмнөговь аймгийн Засаг даргын хамтарсан 2016 оны 03 сарын 25-ны өдрийн 195...1...1204 тоот тушаал, захирамжийн хоёрдугаар хавсралт

## **АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Даланзадгад сумын Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам, хэрэгжүүлэх арга хэмжээг тогтооход энэхүү журмын зорилго оршино;

1.2. Энэхүү журмыг Даланзадгад сумын агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд дагаж мөрдөнө.

### **Хоёр: Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэм**

2.1. Агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар дараах дэглэмийг мөрдөнө;

2.1.1. Стандартын шаардлага хангасан дэвшилтэт техник технологи бүхий бүтээгдэхүүн хэрэглэх;

2.1.2. Агаарын чанарыг сайжруулах бүсэд стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг хэрэглэх бөгөөд стандарт шаардлага хангасан бүтээгдэхүүнд дараах төрлийн бүтээгдэхүүн хамаарагдана. Үүнд:

2.1.2 Монгол Улсын болон олон улсын стандарт шаардлагад нийцсэн сайжруулсан зуух / MNS EN 13240: 2011 " Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утаа дахь агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээ ба хэмжих арга" MNS 5457: 2005" Сайжруулсан түлш", MNS 5679:2011/ болон сэргээгдэх эрчим хүч ( нар, салхи, газрын гүний дулаан) , био түлш ( ургамал, амьтны гаралтай тосноос гарган авсан шингэн), цахилгаан, бүх төрлийн хийн халаагуур зэрэг багтана;

2.1.3. Дулаан алдагдлыг багасгах зориулалттай стандартад нийцсэн нэмэлт дулаалга хэрэглэх;

2.1.4. Халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага агаарын бохирдолыг бууруулах тоног төхөөрөмж суурьлуулах;

2.1.5. Сайжруулсан зуухнаас бусад зуухыг ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэхийг багасгах, (хэрэглэхгүй байх);

2.1.6. Сайжруулсан түлшийг түлхүү хэрэглэх;

2.1.7. Агаарын чанарын стандартыг хангаагүй техник, технологи, тоног төхөөрөмж ашиглахгүй байх;

2.1.8. Агаарын чанарын мэргэжлийн алба болон орон нутгийн УЦУОША-ны Ус орчны шинжилгээний хэлтсийн дүгнэлтгүй бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг агаарын бохирдолын эх үүсвэр ашиглахгүй байх;

### **Гурав: Агаарын чанарыг сайжруулах бүсэд хэрэгжүүлэх арга хэмжээ**

3.1. Агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа айл өрх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг гаргаж, мэдээллийн санг хөтлөх;

3.2. Албан татвар төлөгч иргэн өөрийн хэрэгцээнд зориулан стандартын шаардлагад хангасан бүтээгдэхүүн худалдан авсан нь баримтаар нотлогдож байгаа бол төлбөрийн хэмжээтэй тэнцэх орлогыг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.15-д заасны дагуу татвараас чөлөөлөх;

3.3. Аж ахуйн нэгж байгууллага Засгийн газраас тогтоосон жагсаалтад заасан стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг худалдан авсан бол тухайн бүтээгдэхүүний үнийн дүнтэй тэнцэх орлогыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-д заасны дагуу татвараас чөлөөлөх;

3.4. Агаарын бохирдолыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад чиглэсэн аливаа хэрэглээ, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;

3.5. Агаарын бохирдолын эх үүсвэр, сөрөг үр дагавар, агаарын бохирдолыг бууруулах техник, технологи, бүтээгдэхүүний ач холбогдол, ахуйн хэрэглээнд шатдаг хий ашиглах, аюулгүй ажиллагааны талаар сургалт сурталчилгаа явуулах;

### **Дөрөв: Оролцогч талуудын эрх, үүрэг**

#### **4.1. Төрийн байгууллагын эрх үүрэг**

4.1.1. Өмнөговь аймгийн Засаг дарга энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулна;

4.1.2. Сумын Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана;

4.1.3. Багийн Засаг дарга агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг гаргаж, бүртгэлийн мэдээллийг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор Агаарын бохирдолыг бууруулах дэд хороо, агаарын чанарын албанд хүргүүлнэ.

4.1.4. Аймгийн УЦУОША-ын Ус орчны шинжилгээний хэлтэс агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн санг хөтлөн явуулна.

#### **4.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг**

4.2.1. Энэхүү журмын 2.1-т заасан дэглэмийг мөрдөж ажиллах;

4.2.2. Агаарын бохирдолыг бууруулах чиглэлээр зохион байгуулагдаж байгаа сургалт сурталчилгаанд оролцох;

4.2.3. Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журамыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаар харъяалах багийн Засаг даргад мэдээллэх;

4.2.4. Хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

**Тав: Хариуцлага**

5.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд “ Агаарын тухай” хуулийн 31.1.3 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-oOo-